

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ АНХДУГААР ЧУУЛГАН

2024 ОНЫ 07 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-12</i>
<hr/>	
<i>1.Байнгын хорооны даргыг сонгох тухай</i>	<i>4-9</i>
<i>2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг шинэчлэн тогтоох эсэх асуудлаар шийдвэр гаргах тухай асуудал</i>	<i>9-13</i>

**Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн бүрэн эрхийн анхдугаар чуулганы
Төсвийн байнгын хорооны 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 05 цаг 10 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, С.Амарсайхан, Т.Аубакир, Ж.Батжаргал, Х.Болормаа, Г.Ганбаатар, П.Ганзориг, Х.Ганхуяг, Г.Дамдинням, З.Мэндсайхан, Д.Пүрэвдаваа, Ч.Ундрэм.

Нэг.Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул байлцав.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэн Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Чойжилсүрэн: Төсвийн зарлагын хяналтын дэд хороог Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Д.Батлут, Х.Булгантуяа, Г.Дамдинням, З.Мэндсайхан, Б.Заяабал, Д.Батбаяр, Б.Түвшин, Д.Цогтбаатар, Р.Батболд, Д.Пүрэвдаваа, П.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 05 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны даргыг сонгох тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнг Төсвийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байгаа талаар танилцуулав.

Танилцуулга болон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны даргад нэр дэвшигч Ц.Даваасүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд үг хэлээгүй болно.

Б.Чойжилсүрэн: Төсвийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатарыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 1
Бүгд: 13
92.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 13 минут үргэлжилж, 25 гишүүнээс 13 гишүүн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр 05 цаг 23 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН
ДАРГАЛАГЧ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Үндсэн
хууль” танхим 05 цаг 10 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Чойжилсүрэн: Төсвийн байнгын хорооны гишүүдийнхээ амрыг эрье ээ. Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж ирц 52 хувьтай бүрдсэн тул Төсвийн байнгын хорооны 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хуралдаанд ирсэн гишүүдийг танилцуулна аа.

Далай овогтой Батбаяр гишүүн ирсэн байна. Ренчиндоржийн Батболд гишүүн ирсэн байна. Жигжидийн Батжаргал гишүүн ирсэн байна. Дамбын Батлут гишүүн ирсэн байна. Жадамбаагийн Баясгалан гишүүн ирсэн байна. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн ирсэн байна. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн ирсэн байна. Батжаргалын Заяабал гишүүн ирсэн байна. Баатаржавын Мөнхсоёл гишүүн ирсэн байна. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн ирсэн, Банзрагчийн Түвшин гишүүн ирсэн байна. Даваагийн Цогтбаатар гишүүн ирсэн байна. Баттогтохын Чойжилсүрэн тэргүүтэй гишүүд ирсэн байна.

Та бүхэнд хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

1.Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудал,

2.Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудал

гэсэн 2 асуудал хэлэлцүүлэхээр танилцуулж байна аа.

Та бүхэнд өөр саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудлаа баталъя аа.

Мөнхбаатар дарга ХЗБХ-н дээр ажилтай байгаа учраас 2 дахь асуудлыг хэлэлцээд явж байя.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг хэлэлцье ээ.

Төсвийн төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд орох гишүүдийн нэрсийг танилцуулъя.

Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд орох гишүүдийн нэрсийг танилцуулъя.

Жигжидийн Батжаргал 5 дугаар тойрог МАН, 4 дүгээр тойрог Дамбын Батлут, 8 дугаар тойрог Хүрэлбаатарын Булгантуяа, 5 дугаар тойрог Гонгорын Дамдинням, 2 дугаар тойрог Загджавын Мэндсайхан, 2 дугаар тойрог Батжаргалын Заяабал, 5 дугаар тойрог Д.Батбаяр, 2 дугаар тойрог Б.Түвшин, 1 дүгээр тойрог Д.Цогтбаатар. Гурвуулаа АН байна. 11 дэх гишүүн Ренчиндоржийн Батболд жагсаалтын гишүүн Иргэний Зориг ногоон нам байгаа юм байна.

12 дахь нь Даваахүүгийн Пүрэвдаваа гэсэн ийм 12 гишүүний нэр энэ чинь 12 болчихсон. 13 болгох ёстой биз дээ? Болохгүй дээд тал нь 12. Пүрэвжавын Ганзориг гишүүн ХҮН намын гишүүн. Ийм 12 гишүүн Төсвийн зарлагын хяналтын дэд хороод хороонд оруулах саналтай байгаа юм байна аа.

Дэд хорооны бүрэлдэхүүнд орох гишүүдийн талаар саналтай гишүүд байна уу? Алга байна аа.

Дэд хорооны бүрэлдэхүүнд орсон гишүүдээс асуух асуулттай гишүүд байна

уу? Алга байна аа үг хэлэх гишүүд байна уу? Алга байна аа. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүү сая уншсан 12 нэрсийг оруулахыг дэмжье гэдэг томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Санал хураалтад 13 гишүүн оролцож санал 69.2 хувиар дэмжигдсэн байна аа.

Төхөөрөмж гацсан гишүүд байна уу? Протоколд хэлээд дэмжсэнээр. Даваагийн Батбаатар гишүүн, Булгантуяа гишүүн үү? 2 гишүүн дэмжсэнээр протоколд тусгая.

Ингээд нэмэхээр Байнгын хорооны ажлын хэсгийнхэн. 2 гишүүн нэмчихнэ шүү дээ, хувь нь өөрчлөгдөнө шүү дээ. 69.2 хувь. Протоколдоо тусгаарай. 84.6 хувь юм байна шүү. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Батбаяр танилцуулчих уу? Батбаяр танилцуулчихъя.

2 дахь асуудлыг хэлэлцэж дууслаа.

Гишүүдээ түр хүлээж байгаарай. Мөнхбаатар дарга удахгүй ороод ирнэ.

05.15 цагт

Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцэж эхэлье ээ.

Байнгын хорооны даргад нэр дэвшигчийн танилцуулгыг Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дарга Лхагвын Мөнхбаатар дарга танилцуулна. Мөнхбаатар даргын микрофон өгье.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн амрыг эрье ээ.

МАН-ын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэнг Төсвийн байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байна аа. Даваасүрэн гишүүний товч намтрыг танилцуулъя.

1983 онд Хөвсгөл аймгийн Мөрөн хотын 10 жилийн 1 дүгээр дунд сургууль, 1989 онд ЗХУ-ын Харьков Хотын Политехникийн дээд сургууль, 1994 онд Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институт, Бизнесийн удирдлагын менежер мэргэжлээр, 1998 онд Япон улсын Сайтомогийн их сургуулийг Эдийн засагч мэргэжлээр тус тус төгссөн.

1989-1992 онд Төвийн эрчим хүчний системд автоматикийн инженер, 1995-1999 онд Сангийн яамны Валютын харилцааны газарт мэргэжилтэн, 1999-2000 онд Сангийн яамны Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга, Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын Гадаад харилцааны хэлтсийн дарга, 2000-2005 онд Санхүү эдийн засгийн яамны Төрийн сангийн газрын дарга, 2005-2008 онд БШУЯ-ны Санхүү эдийн засгийн газрын дарга, 2005 онд Монгол Улсын Шадар сайдын эдийн засгийн зөвлөх, 2008-2012 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн 2009-2010 онд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, 2012-2016 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2012-2014 онд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, 2016-2020 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2017-2020 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрчим хүчний сайд, 2020-2024 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2021 онд Оюутолгойн түр хорооны дарга, 2023 оноос Монгол Улсын Засгийн газрын гишүүн Барилга, хот байгуулалтын сайд, 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна аа.

Монгол Улсын Их Хурлын гишүүн
Цэрэнпилийн Даваасүрэнг Төсвийн
байнгын хорооны даргаар дэмжиж
өгөхийг гишүүдээс хүсэж байна аа.

Б.Чойжилсүрэн: Мөнхбаатар
даргад баярлалаа.

Байнгын хорооны даргад нэр
дэвших талаар өөр саналтай гишүүд
байна уу? Алга байна.

Нэр дэвшигчээс асуух асуулттай
гишүүд байна уу? Түвшин гишүүнээр
тасалъя.

Түвшин гишүүн асуултаа асууя.

Б.Түвшин: Даваасүрэн даргад нэр
дэвшиж байгаад баяр хүргэе ээ.

Ганцхан асуулт байна аа. Төсвийн
хорооны хуульд заасан яг эрх үүргийн
хүрээнд ашиг сонирхлоос ангид байж
чадах уу л гэж ганцхан асуулт л асууя.

Б.Чойжилсүрэн: Даваасүрэн
гишүүн асуултад хариулъя.

Ц.Даваасүрэн: Ашиг сонирхлын
ямар нэг зөрчил байхгүй ээ.

Б.Чойжилсүрэн: Гишүүд асуулт
асууж дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу?
Алга байна.

Гишүүд асуулт асууж, үг хэлж
дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы
хуралдааны дэгийн тухай хуулийн 10
дугаар зүйлийн 12-т заасны дагуу санал
хураалтыг зүгээр шууд явчихъя даа.

Шууд санал хураалтаар авчихъя.

Төсвийн байнгын хорооны дарга
Цэрэнпил овогтой Даваасүрэнг нэр
дэвшүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор
санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Санал хураалтад 13 гишүүн
оролцож санал 84.6 хувиар дэмжигдлээ.

Протоколд үг аваад хэлээдэх.

Мөнхтулга гишүүний микрофоныг
өгье.

Мөнхтулга гишүүний саналыг
дэмжсэнээр тооцъё.

Ц.Мөнхтулга: Төхөөрөмж дээр
хурууны хээгээ дарсан, зөвшөөрсөн,
татгалзсан гэсэн 2 сонголт гарч ирсэн.
Зөвшөөрснийг дарсан. Үр дүн гарч ирэхэд
миний нэр гарч ирээгүй ээ. Тийм учраас
протоколд тэмдэглүүлж байгаа юм.

Б.Чойжилсүрэн: Мөнхтулга
гишүүнд баярлалаа.

Саналын дүн 84.6-аас нэмэгдэх нь
байна шүү дээ Байнгын хорооныхон.

13 гишүүн санал хураалтад
оролцож, 12 гишүүн дэмжлээ.

Байнгын хорооны даргад нэр
дэвшүүлэх асуудлыг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны хуралдаан
хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан
хаасныг мэдэгдье.

Санал дүгнэлтийг унших ёстой юм
байна. Батлут гишүүн унших уу.

Байнгын хорооны хуралдаан
дууслаа. Баярлалаа гишүүд ээ.

05.23 цагт

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ
П.МЯДАГМАА

